



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ

2019 оны 04 сарын 04 өдөр

Дугаар А/90


Улаанбаатар хот


Ажлын хэсэг байгуулах тухай

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2 дугаар хэсгийн 2.88, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2 дугаар хэсгийн 2.3.8, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан "Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам"-ын 2 дугаар хэсгийн 2.4.1, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5 дахь заалтуудыг тус тус үндэслэх ТУШААХ нь:


1. Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 388, 2019 оны 46 дугаар тогтоолын хавсралтаар байгуулагдсан Барилга байгууламжийн дулаан алдагдлыг бууруулах төсөл арга хэмжээний XI.2.6, XI.2.16, XI.2.22, XI.2.23, XI.2.24, XI.2.29, XI.2.30 дахь заалт бүхий төсөл арга хэмжээний хэрэгжилтэд зохиогчийн хяналт хэрэгжүүлэх, барилга угсралтын явцад мэргэжил арга зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх, эрчим хүчний хэмнэлтийг тооцох, оршин суугчдын оролцоо уялдаа холбоог хангаж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал боловсруулах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор байгуулсугай.

2. Ажлын хэсгээс авч хэрэгжүүлсэн болон цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх саналыг Улаанбаатар хотын Ерөнхий менежерт сар бүрийн 30 - ны өдөр танилцуулж, ажлаа сурталчлан ажиллахыг Ажлын хэсэг /Т.Хэрлэн/-т үүрэг болгосугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА  Т.ГАНТӨМӨР



Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2019 оны 01 сарын 01-дрийн
А/30 тушаалын хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга	Т.Хэрлэн	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Инженерийн байгууламжийн хэлтсийн дарга
Гишүүд	О.Энхтуяа	Барилга, хот байгуулалтын яам Нийтийн аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Ахлах мэргэжилтэн /зөвшилцсөнөөр/
	Д.Жүрмэддорж	Хот Байгуулалт, хөгжлийн газрын Барилгын чанар, аюулгүй байдлын хэлтсийн Ахлах мэргэжилтэн /зөвшилцсөнөөр/
	М.Батбаатар	Монголын барилгачдын нэгдсэн холбооны Дэд ерөнхийлөгч /зөвшилцсөнөөр/
	Н.Дорж	Барилгын зураг төсөл зохиогчдын холбооны Ерөнхийлөгч /зөвшилцсөнөөр/
	О.Лхагвадорж	Монголын барилгын материал үйлдвэрлэгчдийн холбооны гүйцэтгэх захирал /зөвшилцсөнөөр/
	А.Цогт	Эрчим төсөл ХХК-ны дулаан халаалт агаар сэлгэлтийн инженер
	Ж.Пүрэвжамц	Орон сууц нийтийн аж ахуйн газар ОНӨААТҮГ- ын Инженерийн бодлого, хяналтын хэлтсийн дарга
	С.Түвшинхүү	Германы Олон Улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ) - ийн төслийн менежер
	Н.Тод-од	Гандирс од ХХК - ны захирал
	Б.Мөнхбаяр	Шинжлэх ухаан технологийн их сургуулийн багш
М.Галбаатар	Монголын Сууц өмчлөгчдийн холбоодын дээд зөвлөлийн гүйцэтгэх захирал	
Нарийн бичгийн дарга	Б.Отгонбат	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Инженерийн байгууламжийн хэлтсийн мэргэжилтэн